



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 04 сарын 30 өдөр

Дугаар А/61

Ховд

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Боловсрол, соёл, спортын салбарын болон төсөвт байгууллагуудын тоног төхөөрөмж, компьютер техник хэрэгсэл, тавилга эд хогшлын шинэчлэл /Ховд, Булган сум/ ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Дарга: Ш.Нохойжав -Орон нутгийн өмчийн газрын дарга
Гишүүдэд: Б.Нямдорж - Боловсрол, соёл, урлагийн газрын төсөв,
хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн

Л.Дорждэрэм -Төрийн бус байгууллагын төлөөлөл
М.Энхболд - Иргэний төлөөлөл

Нарийн бичгийн дарга: Э.Цолмон -Орон нутгийн өмчийн газрын Худалдан
авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

2.Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхолын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо /Ш.Нохойжав/-нд даалгасугай.

3.Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга / Э.Цолмон /-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД